



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2021 он 04 дугаар
сарын 29-ны өдөр

Дугаар ХАГ/1170

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011


МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
Г.ЗАНДАНШАТАР ТАНАА

Ерөнхий сайдын мэдээллийн тухай

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нөхцөл байдал, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар хийх мэдээллийг Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганы 2021 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн нэгдсэн хуралдаанд танилцуулахыг Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнээс Монгол Улсын Шадар сайд С.Амарсайханд үүрэг болгосныг үүгээр уламжилж байна.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга




Ц.НЯМДОРЖ

000021507094



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2021 он 04 дугаар
сарын 29-ны өдөр

Дугаар ХЭГ/1169

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
Г.ЗАНДАНШАТАР ТАНАА

Мэдээлэл хүргүүлэх тухай

Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганы 2021 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн нэгдсэн хуралдаанд хийх Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нөхцөл байдал, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх мэдээллийг хүргүүлж байна.

Хавсралт 9 хуудастай.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Ц.НЯМДОРЖ

**КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ЦАР ТАХЛЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ,
АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР УЛСЫН ИХ ХУРЛЫН
ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНД ХИЙХ МЭДЭЭЛЭЛ**

Нэг. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын нөхцөл байдлын талаар

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахал 2021 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн байдлаар дэлхийн 226 улсад тархаж, 147.5 сая хүн өвчлөн, 3.1 сая хүн нас барсан байна.

Харин манай улсад 2021 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн байдлаар коронавируст халдварын 32,437 батлагдсан тохиолдол бүртгэгдсэнээс 451 нь гадаад орноос зөөвөрлөгдсөн байна. Түүнчлэн Европын орнуудаас ирсэн 6 иргэнээс Англи маягийн мутацлагдсан хэлбэрийн вирус илэрснийг геномын шинжилгээгээр баталгаажуулах ажил хийгдэж байна.

Коронавируст халдвараар өвчилж эдгэрсэн 17,543 (54.1 хувь) иргэн байгаа бол клиникт хэвтэн эмчлүүлж байгаа 4427 иргэн (нийслэлд 3296, орон нутагт 1131 иргэн) байна. Коронавируст халдварын улмаас суурь өвчин хавсарсан байдлаар 8 иргэн, халдварын улмаас 88 иргэн, нийт 96 иргэн нас барсан бол 80 иргэний биеийн байдал нэн хүнд, 11 эмнэлэгт эрчимт эмчилгээнд байна.

№	Эмнэлгийн нэр	Эмнэлзүйн байдал				Нийт
		Хөнгөн	Хүндэвтэр	Хүнд	Нэн хүнд	
1	ХӨСҮТ	105	105	31	14	255
2	ЦТЭ	146	115	29	9	299
3	ЭНЭҮТ-2	354	262	53	11	680
4	СБДНЭ	43	108	20	10	181
5	СХДНЭ	67	49	43	6	165
6	БГДЭМТ	16	79	16	0	111
7	БГД ахмадын эмнэлэг	23	58	45	0	126
8	Ачтан	74	25	7	0	106
9	Сэргээн засах клиник эмнэлэг	116	42	0	0	158
10	Хорих 409, 421, 461-р ангиуд	233	13	0	0	246
11	Багануур	18	1	0	0	19
12	УНТЭ	11	56	20	0	87
13	УХТЭ	0	34	7	7	48
14	УГТЭ	0	69	10	4	83
15	ГССҮТ	2	12	2	1	17
16	АӨСҮТ	32	9	0	0	41
17	СЭМҮТ	25	15	0	0	40
18	БЗДНЭ	3	118	17	11	149
19	Жаргалант	55	5	0	0	60
20	Монгол-Японы хамтарсан эмнэлэг	15	40	17	3	75
21	Амгалан амаржих газар	6	0	0	0	6
22	ХБХүүхдийн сэргээн засах төв	70	14	2	0	86
23	ТТАХНЭ	85	25	10	0	120
24	АШУУИС төв эмнэлэг	71	0	0	0	71
25	ХСҮТ	6	2	2	3	13
26	Өргөө амаржих газар	10	0	0	0	10
27	ЭХЭМҮТ	0	19	0	0	19

28	УБТЗ-ын төв эмнэлэг	19	5	1	0	25
29	Архангай	41	6	0	0	47
30	Баян-Өлгий	4	0	0	0	4
31	Баянхонгор	12	3	1	0	16
32	Булган	11	0	0	0	11
33	Говь-Алтай	0	0	0	0	0
34	Говьсүмбэр	9	2	0	0	11
35	Дархан-Уул	239	7	1	0	247
36	Дорноговь	0	0	0	0	0
37	Дорнод	24	3	0	0	27
38	Дундговь	25	4	1	0	30
39	Завхан	122	60	3	0	185
40	Орхон	43	10	0	0	53
41	Өвөрхангай	64	3	0	0	67
42	Өмнөговь	0	0	0	0	0
43	Сүхбаатар	74	5	0	0	79
44	Сэлэнгэ	25	0	0	0	25
45	Төв	146	55	3	0	204
46	Увс	19	3	0	0	22
47	Ховд	67	1	2	1	71
48	Хөвсгөл	13	4	0	0	17
49	Хэнтий	14	1	0	0	15
Бүгд		2557 (57.8%)	1447 (32.7%)	343 (7.7%)	80 (1.8%)	4427

Хүснэгт 1. Халдвар авсан иргэдийн эмнэлзүйн байдал

Коронавируст халдвар авч, биеийн байдал нэн хүндэрсэн иргэдийг эмчлэх зорилгоор Эрүүл мэндийн яамнаас сэхээний нарийн мэргэжлийн 22 эмчилгээний багийг бэлтгэн ажиллуулж байна.

Хоёр. Авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, халдварын тархалтын өсөлтийг зогсоох, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, Улсын Их Хурлаас батлан гаргасан хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиглэлээр Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комиссоос 90 гаруй тогтоол шийдвэр, нөхцөл байдлыг зохицуулах 20 гаруй журам, заавар гарган хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.

Манай улсад тархсан халдварт цар тахлын одоогийн нөхцөл байдал, цаашид бий болох эрсдэлийн талаар мэргэжлийн эрдэмтэн судлаачдын болон эрүүл мэндийн эмч, мэргэжилтнүүдийн хамтран гаргасан судалгаа тооцоо, гадаад орнуудын туршлага дээр үндэслэн цаг үеийн болон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж, Улсын онцгой комиссын хуралдаан, шуурхай хурлаар хариу арга хэмжээг төлөвлөн, хэрэгжилтийг тухай бүр зохион байгуулж байна.

Улсын онцгой комиссын дэргэдэх эрдэмтэн, судлаачдын гаргасан урьдчилсан тооцоогоор хөл хорио хязгаарлалтын дэглэмийг тогтоосноор 2021 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар 190,000 болох байсан тохиолдлын тоог 60,000 хүртэл буюу 3 дахин бууруулах боломжтой байна.

Дэлхийн Эрүүл мэндийн байгууллагын судалгаагаар коронавируст халдварын эсрэг дархлаажуулалтын үр дүнгээр Астразенека вакцин 72 хувь, Синофарм үйлдвэрийн вакцин 86 хувь байгаа бөгөөд манай улсын хувьд вакцины

хоёрдугаар тунг 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн дотор бүрэн хамруулахад дундаж үр дүн, нөлөө 80 хувьтай тэнцэнэ гэсэн тооцоо, магадлалыг гаргасан.

Халдварт цар тахлын аюулын зэргийн үнэлгээгээр манай улсад халдварын тархалт 2021 оны 3 дугаар сарын сүүлээс эрс нэмэгдэх, хатуу хөл хорио, хязгаарлалт тогтоохгүй бол 4 дүгээр сарын дунд үе гэхэд халдвар авсан иргэдийн тоо өдөрт дунджаар 2400-д хүрэх, үүний дотор хүнд, нэн хүнд хүний тоо эрс өсөж, нас баралт өдөрт 20 орчимд хүрнэ гэсэн судалгаа, тооцоо гарсан тул эхний ээлжид авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг тодорхойлон хэрэгжүүлж байна.


Мөн эрүүл мэндийн салбарын бодит хүчин чадал, эм тариа, халдвар хамгааллын хэрэгслийн нөөц, хүчил төрөгч, эмчилгээний орны хүрэлцээ, иргэдийн хөдөлгөөн, идэвх, хүн амын амьжиргаа, зан үйл зэрэг олон талын асуудлыг нягтлан үзсэний үндсэн дээр цар тахалтай тэмцэх ажлыг богино хугацаанд олон хувилбараар зохион байгуулах бодит шаардлага байнга тулгарч байна.

Цаг үеийн нөхцөл байдал, өдөр тутам нэмэгдэж байгаа олон талын эрсдэл нь цар тахалтай тэмцэхэд ихээхэн хүндрэл учруулж байгаа ч нийтэд тархсан өвчлөлийн хавьтлыг тогтоох, хяналтдаа авах, дам болон ойрын хавьтлыг тусгаарлан гэрийн хяналтад оруулах, эм, эмнэлгийн тусламжийн чанарыг сайжруулах, хөнгөн хэлбэрээр өвчилсөн иргэдийг гэрээр өрхийн эмчийн болон явуулын эмч нарын багийн хяналт дор эмчилгээний багц олгож эмчлэх, суурь өвчтэй, хүнд хэлбэрээр өвчилсөн иргэдийг эмнэлгийн ор нэмж дэлгэх байдлаар хэвтүүлэн эмчлэх, ахмад настнуудад дархлаажуулалтын багц олгож дархлааг нь хамгаалах, эмч, мэргэжилтнүүд, түргэн тусламжийн автомашины тоо, хүчил төрөгчийн хангамжийг нэмэгдүүлэх, өдөр тутам байнга давтан хяналттай гүйцэтгэх ажлууд зэрэг 240 гаруй асуудлыг цаг хугацаатай уралдан зохион байгуулах, үүссэн асуудлыг түргэн шуурхай шийдвэрлэхээр хариу арга хэмжээнд оролцож байгаа бүх байгууллага, албан хаагчид 24 цагаар ажлын өндөр ачаалалтай ажиллаж байна.

Нэн түрүүнд цар тахлаар өвчилсөн иргэдэд шаардлагатай хүчил төрөгчийн хангамжийг яаралтай нэмэгдүүлэх, эм хангамжийн нөөц бий болгох, шинжилгээний урвалж бодис, түргэн оношлуурыг гадаад зах зээлээс хямд өртгөөр авч, аймаг, сум, нийслэл, дүүрэгт яаралтай олгох, ПГУ шинжилгээний дараалал, чирэгдлийг багасгах, эмнэлгийн тусламжийн орны хүрэлцээг 3 үе шаттайгаар нэмэгдүүлэх, вакцинжуулалтыг өргөн хүрээнд зохион байгуулах бэлтгэлийг хангаж, зохих арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Коронавируст халдварын сэргийлэлт, хяналт, оношилгоо, эмчилгээнд гэхэд 5197 эрүүл мэндийн ажилтан (их эмч 1275, сувилагч 1354, тархвар судлаач 126, бусад ажилтан 2442) ажиллаж байна. Үүнээс тусгаарлан ажиглалтын 21 байрлалд 27 их эмч, 25 резидент эмч, бусад 163 эмнэлгийн мэргэжилтэн тусламж, үйлчилгээ үзүүлж байна.

Коронавируст халдварын өсөлтийг сааруулахын тулд 2021 оны 4 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн 16 хоног бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн нь халдвар тархах эрсдэлийг 50 хувиар, нас баралтыг 60 хувиар бууруулсан. Гэвч бүх нийтийн хөл хорио зохих түвшинд хүрээгүйгээс халдварын тоо буураагүй, цаашид яаралтай арга хэмжээ авахгүй бол хэвээр хадгалагдах нөхцөл байдал ажиглагдсан тул дахин 12 хоногоор сунгах шийдвэр гаргасан.



Зураг 1. 2021 оны 4 дүгээр сард батлагдсан тохиолдол

Цар тахлын халдвар нь гэр бүл, байгууллагын хүрээнд, оршуулга, буяны ажил, зах, худалдааны төв, үзвэр, үйлчилгээ зэрэг иргэд олноор цугладаг газруудад тархаж байгааг тогтоосны дагуу эхний ээлжид бүх нийтийн бэлэн байдлын “улаан зэрэг”-т үйл ажиллагааг хязгаарлаагүй төрийн байгууллага, хуулийн этгээдэд дахин зохицуулалт хийж, халдварыг багасгах арга хэмжээг авсан. Гэвч иргэд, гэр бүл, ахуйн хүрээнээс халдварлах явдал багасахгүй байгаа учир халдвар авсан иргэдийг гэр бүлээс нь тусгаарлах, эрсдэлтэй, суурь өвчтэй иргэдийг эмнэлэг, тусгаарлах байранд шилжүүлж эмчлэх ажлыг эхлүүлээд байна.

Д/д	Нийслэл, аймгийн нэр	Эмнэлэгт	Хүн	Тусгаарлах байранд	Хүн	Нийт тусгаарлах байр	Нийт тусгаарлагдсан хүн	Үүнээс гадаад улсын иргэн
1	Улаанбаатар	22	2849	24	502	46	3487	56
2	Архангай	1	39	5	47	6	86	-
3	Баян-Өлгий	2	21	-	-	2	21	-
4	Баянхонгор	1	16	4	16	5	32	-
5	Булган	2	3	1	16	3	19	-
6	Говьсүмбэр	1	11	1	1	2	12	-
7	Дархан-Уул	3	168	5	218	8	378	-
8	Дорноговь	-	-	-	-	-	-	-
9	Дорнод	1	18	-	-	-	18	-
10	Дундговь	2	39	2	17	4	56	-
11	Завхан	5	168	-	-	5	168	-
12	Орхон	1	53	1	22	2	75	-
13	Өвөрхангай	2	46	6	66	8	112	-
14	Сүхбаатар	3	90	7	39	10	129	-
15	Сэлэнгэ	3	37	-	-	3	37	-
16	Төв	4	182	5	44	7	226	-
17	Увс	1	17	1	10	2	27	-
18	Ховд	1	64	7	177	8	241	-
19	Хөвсгөл	4	18	-	-	4	18	-
20	Хэнтий	1	14	1	4	2	18	-
	Бүгд	60	3853	68	1163	127	5160	56

Хүснэгт 2. Эмнэлэг, тусгаарлан ажиглах байрны мэдээлэл

Гурав. Эмнэлгийн тусламж, үйлчилгээ, орны төлөвлөлтийн талаар

Сүүлийн өдрүүдэд халдварын тархалт эрс нэмэгдсэнтэй холбоотойгоор улсын болон хувийн хэвшлийн эмнэлгийг дайчлан ашиглаж байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар нийслэлд 28 эмнэлгийн эрчимт эмчилгээний 80, энгийн эмчилгээний 666 ор, аймаг, орон нутгийн 24 эмнэлэгт эрчимт эмчилгээний 168, энгийн 3151 ор сул байна.

Болзошгүй үед ашиглах зорилгоор "Буянт-Ухаа" спорт цогцолборт 300 ор дэлгэхээр бэлтгэж, 3 ээлжээр нийт 180 эмч, эмнэлгийн мэргэжилтэн /45 эмч, 90 сувилагч, тусгай мэргэжилтэн 45/, бусад албан хаагчдыг ажиллуулах тооцоог гаргасан.

Түүнчлэн АШУҮИС-ийн Монгол-Японы эмнэлгийн оюутны байранд 450 ор дэлгэн халдварын тохиолдлыг тусгаарлан эмчлэх нэгжийг хуваарилж, хөнгөн хэлбэрийн өвчтөнүүдийг шилжүүлэх, Архангайн оюутны дотуур байранд 150 ор бэлтгэж, эхний ээлжийн ашиглалтыг тус тус эхлүүллээ.

Мөн ШУТИС-ийн оюутны I байр, АШУҮИС-ийн II, III дугаар байр, Архангайн оюутны дотуур байрны нийт 337 өрөөний 1980 орыг төлөвлөж, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын гаргасан зөвлөмжийн дагуу эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эмч, ажилчид, хамгаалалтад ажиллах албан хаагчид зэрэг нийт 844 хүнийг ажиллуулах тооцоог гаргаад байна.

Цаашид хөнгөн өвчтөнүүдийг тусгаарлан эмчлэх зориулалтаар нийслэлийн хэмжээнд 7 дүүрэгт хувийн хэвшлийн 52 эмнэлгийн 949 ор, 23 сувиллын 1080 ор, нийт 2029 орыг нэмэлтээр, 6 дүүрэгт 152 амралтын газрын 7940, 16 жуулчны баазын 1320 ор, нийт 9260 орыг дайчлан ажиллуулах тооцоог гаргасан.

Дөрөв. Эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн талаар

Улсын хэмжээнд коронавируст халдварын үед шаардлагатай 37 нэр төрлийн нийт 5.0 тэрбум төгрөгийн эмийн нөөц, 16 нэр төрлийн нийт 38.3 тэрбум төгрөгийн хувийн хамгаалах хэрэгслийн нөөцтэй байна.

Эрүүл мэндийн байгууллагуудад нийт 984 амьсгалын аппарат (үүнээс зөөврийн 137) ашиглагдаж байгаагаас төрөлжсөн мэргэшлийн эмнэлгүүдэд 501 (үүнээс зөөврийн 30), Нийслэлийн Эрүүл мэндийн газрын харьяа байгууллагад 231 (үүнээс зөөврийн 77), орон нутгийн эрүүл мэндийн байгууллагад 252 (үүнээс зөөврийн 60) амьсгалын аппарат байна.

Улсын хэмжээнд ПГУ-ийн кит 22,384, ПГУ-ийн ялгах кит 54,685, GENE EXPERT/Cartridge 238, хамар залгиурын түргэвчилсэн оношлуур 65,927, ийлдэс болон бүхэл цусны түргэвчилсэн оношлуур 6,299 ширхэг нөөцтэй байна.

Эрүүл мэндийн яамнаас 2021 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр 18 эрүүл мэндийн байгууллагад 111 ширхэг хүчил төрөгч өтгөрүүлэгч аппарат хуваарилан олгож, хүчил төрөгчийн нөөцийн хангалт 86.4 хувьтай байна.

Түүнчлэн Халдварт өвчин судлалын үндэсний төвийн эрчимт эмчилгээний тасагт нэн шаардлагатай хүчил төрөгчийн үйлдвэрийг шуурхай барьж, 4 дүгээр сарын 28-ны өдөр ашиглалтад оруулахаар төлөвлөж байна.

Тав. Коронавируст халдварын эсрэг дархлаажуулалтын явцын талаар

Дэлхий нийтээр коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцины нийт 275 хөгжүүлэлтийг хийж байна. Үүнээс 184 вакцин эмнэлзүйн өмнөх туршилтын шатанд, 91 вакцин эмнэлзүйн туршилтын шатанд явж байгаа бөгөөд одоогоор Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын яаралтай хэрэглэх жагсаалтад 3 вакцин бүртгэгдээд байгаа юм.

2021 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн байдлаар дэлхийн 154 улс орон коронавируст халдварын эсрэг вакцинжуулалтын ажлыг дотооддоо зохион байгуулж, нийт 933 сая тун вакцин (өдөрт дунджаар 18.8 сая тун) хийгдээд байна.

Харин манай улсын хувьд 2021 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн байдлаар нийт 1,450,640 вакцины тунг татан авч, хүн амыг дархлаажуулах ажлыг зохион байгуулж байна.

№	Вакцины нэр	Үйлдвэрлэсэн улс	Үйлдвэрлэгч	Хүлээж авсан тоо /тунгаар/	Хүлээн авсан огноо	Эх үүсвэр
1	АстраЗенека COVISHIELD	БНЭУ	Серум Институт	150,000	2021.02.22	БНЭУ-ын ЗГ
2	Синофарм CorV (Verocell)	БНХАУ	Sinopharm/ BBIBP	300,000	2021.02.22	БНХАУ-ын ЗГ
3	АстраЗенека AZD1222	БНСУ	SK Bioscience	14,400	2021.03.12	КОВАКС хөтөлбөр
4	АстраЗенека AZD1222	БНСУ	SK Bioscience	50,400	2021.04.21	КОВАКС хөтөлбөр
5	Пфайзер/БиоНТех BNT162	Бельги	Пфайзер- БиоНТех	25,740	2021.03.24	КОВАКС хөтөлбөр
6	Спутник-В Гам-КОВИД-Вак	ОХУ	Гамалей институт	10,100	2021.02.27	Монгол эм импекс концерн ХХК
7	Синофарм CorV (Verocell)	БНХАУ	Sinopharm/ BBIBP	300,000	2021.04.02	МУ-ын ЗГ
8	Синофарм CorV (Verocell)	БНХАУ	Sinopharm/ BBIBP	600,000	2021.04.23	МУ-ын ЗГ
НИЙТ				1,450,640		

Хүснэгт 3. Хүлээн авсан нийт вакцин

Нэмэлтээр хүн амын 30 хүртэлх хувийг вакцинжуулахаар 1,000,000 тун Спутник-В вакциныг худалдан авах гэрээ, хэлэлцээрийг тус тус хийгээд байна.

№	Вакцины нэр	Үйлдвэрлэсэн улс	Үйлдвэрлэгч	Хүлээж авах тоо /тунгаар/	Хүлээн авах огноо	Эх үүсвэр
1	АстраЗенека AZD1222	БНСУ	SK Bioscience	48,000	2021.05 сар	КОВАКС хөтөлбөр
2	Пфайзер/БиоНТех BNT162	Бельги	Пфайзер- БиоНТех	100,620	2021.06 сар	КОВАКС хөтөлбөр
3	Спутник-В Гам-КОВИД-Вак	ОХУ	Гамалей институт	1,000,000	2021.04 сар	МУ-ын ЗГ
НИЙТ				1,148,620		

Хүснэгт 4. Вакцин нийлүүлэлтийн төлөвлөгөө

Иргэдийг дархлаажуулах ажлыг эхлэхээс өмнө 21 аймаг, 9 дүүргийн 4553 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, бусад салбарын мэргэжилтнүүдийг хамруулсан 18 удаагийн цахим сургалтыг зохион байгуулсан.

Улсын хэмжээнд 2021 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн байдлаар дархлаажуулалтын нэгдүгээр тунд 744,564 иргэн, хоёрдугаар тунд 262,466 иргэн хамрагдаад байна. Ингэснээр хамрагдвал зохих зорилтот бүлгийн буюу насанд хүрсэн нийт хүн амын 36.0 хувь нь нэгдүгээр тунд, 12.7 хувь нь хоёрдугаар тунд хамрагдаад байна.

№	Аймаг	1-р тун	2-р тун	Нийт
1	АРХАНГАЙ	3,974	66	4,040
2	БАЯН-ӨЛГИЙ	5,105	21	5,126
3	БАЯНХОНГОР	3,455	0	3,455
4	БУЛГАН	2,964	12	2,976
5	ГОВЬ-АЛТАЙ	4,044	12	4,056
6	ГОВЬСҮМБЭР	1,868	26	1,894
7	ДАРХАН-УУЛ	21,909	333	22,242
8	ДОРНОГОВЬ	12,121	67	12,188
9	ДОРНОД	8,332	15	8,347
10	ДУНДГОВЬ	2,546	8	2,554
11	ЗАВХАН	4,619	4	4,623
12	ОРХОН	18,232	1,223	19,455
13	ӨВӨРХАНГАЙ	5,411	16	5,427
14	ӨМНӨГОВЬ	14,537	7,038	21,575
15	СҮХБААТАР	4,405	7	4,412
16	СЭЛЭНГЭ	14,465	2	14,467
17	ТӨВ	5,677	222	5,899
18	УВС	4,115	33	4,148
19	ХОВД	4,640	16	4,656
20	ХӨВСГӨЛ	5,453	19	5,472
21	ХЭНТИЙ	4,330	5	4,335
Аймгийн дүн		152,202	9,145	161,347

№	Дүүрэг	1-р тун	2-р тун	Нийт
1	БАГАНУУР	9,228	2,426	11,654
2	БАГАХАНГАЙ	1,376	803	2,179
3	БАЯНГОЛ	92,638	42,974	135,612
4	БАЯНЗҮРХ	169,960	64,800	234,760
5	НАЛАЙХ	11,836	3,364	15,200
6	СОНГИНОХАЙРХАН	90,068	41,457	131,525
7	СҮХБААТАР	65,616	30,972	96,588
8	ХАН-УУЛ	87,052	42,018	129,070
9	ЧИНГЭЛТЭЙ	64,588	24,507	89,095
Нийслэлийн дүн		592,362	253,321	845,683

Хүснэгт 5. Дархлаажуулалтын явц /2021.04.27/

Нийслэлийн хэмжээнд 2021 оны 4 дүгээр сарын 26-ны өдрөөс 5 дугаар сарын 8-ны өдрийг хүртэлх хугацаанд нийт 250 баг 110 цэгт ажиллаж, өдөрт дунджаар 60,000 хүнд вакцин хийхээр төлөвлөн ажиллаж байгаа бөгөөд нийслэлийн иргэдийг 5 дугаар сарын 8-ны өдөр гэхэд нэгдүгээр тунд, 6 дугаар сарын 4-ний өдөр гэхэд хоёрдугаар тунд хамруулж дуусгахаар төлөвлөж байна.

Вакцин тариулсны дараа халуурах, тариулсан газарт хөндүүрлэх, толгой өвдөх, бие зарайх, үе мөч өвдөх, булчин өвдөх зэрэг хэсэг газрын болон ерөнхий биеийн урвал түгээмэл илэрч байна. АстраЗенека үйлдвэрийн лицензээр үйлдвэрлэсэн вакциныг тариулсан иргэдийн 55.5 хувьд, Синофарм үйлдвэрийн Вероцелл вакциныг тариулсан хүмүүсийн 13 хувьд, Пфайзер/БиоНТех үйлдвэрийн вакциныг тариулсан иргэдийн 41.8 хувьд түгээмэл илрэх хөнгөн урвал илэрсэн байна.

Вакцины төлөвлөлт, эмчийн үзлэг, вакцинд хамрагдсан иргэдийн бүртгэл, мэдээлэл, вакцины сертификатыг цахим бүртгэлийн системүүдэд бүртгэж, илэрч буй урвал, тандалт судалгаа, шинжилгээний ажлыг зохион байгуулж байна.

Иргэдийг дархлаажуулах ажлыг эхлэхээс өмнө 21 аймаг, 9 дүүргийн 4553 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, бусад салбарын мэргэжилтнүүдийг хамруулсан 18 удаагийн цахим сургалтыг зохион байгуулсан.

Улсын хэмжээнд 2021 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн байдлаар дархлаажуулалтын нэгдүгээр тунд 744,564 иргэн, хоёрдугаар тунд 262,466 иргэн хамрагдаад байна. Ингэснээр хамрагдвал зохих зорилтот бүлгийн буюу насанд хүрсэн нийт хүн амын 36.0 хувь нь нэгдүгээр тунд, 12.7 хувь нь хоёрдугаар тунд хамрагдаад байна.

№	Аймаг	1-р тун	2-р тун	Нийт
1	АРХАНГАЙ	3,974	66	4,040
2	БАЯН-ӨЛГИЙ	5,105	21	5,126
3	БАЯНХОНГОР	3,455	0	3,455
4	БУЛГАН	2,964	12	2,976
5	ГОВЬ-АЛТАЙ	4,044	12	4,056
6	ГОВЬСҮМБЭР	1,868	26	1,894
7	ДАРХАН-УУЛ	21,909	333	22,242
8	ДОРНОГОВЬ	12,121	67	12,188
9	ДОРНОД	8,332	15	8,347
10	ДУНДГОВЬ	2,546	8	2,554
11	ЗАВХАН	4,619	4	4,623
12	ОРХОН	18,232	1,223	19,455
13	ӨВӨРХАНГАЙ	5,411	16	5,427
14	ӨМНӨГОВЬ	14,537	7,038	21,575
15	СҮХБААТАР	4,405	7	4,412
16	СЭЛЭНГЭ	14,465	2	14,467
17	ТӨВ	5,677	222	5,899
18	УВС	4,115	33	4,148
19	ХОВД	4,640	16	4,656
20	ХӨВСГӨЛ	5,453	19	5,472
21	ХЭНТИЙ	4,330	5	4,335
	Аймгийн дүн	152,202	9,145	161,347

№	Дүүрэг	1-р тун	2-р тун	Нийт
1	БАГАНУУР	9,228	2,426	11,654
2	БАГАХАНГАЙ	1,376	803	2,179
3	БАЯНГОЛ	92,638	42,974	135,612
4	БАЯНЗҮРХ	169,960	64,800	234,760
5	НАЛАЙХ	11,836	3,364	15,200
6	СОНГИНОХАЙРХАН	90,068	41,457	131,525
7	СҮХБААТАР	65,616	30,972	96,588
8	ХАН-УУЛ	87,052	42,018	129,070
9	ЧИНГЭЛТЭЙ	64,588	24,507	89,095
	Нийслэлийн дүн	592,362	253,321	845,683

Хүснэгт 5. Дархлаажуулалтын явц /2021.04.27/


Нийслэлийн хэмжээнд 2021 оны 4 дүгээр сарын 26-ны өдрөөс 5 дугаар сарын 8-ны өдрийг хүртэлх хугацаанд нийт 250 баг 110 цэгт ажиллаж, өдөрт дунджаар 60,000 хүнд вакцин хийхээр төлөвлөн ажиллаж байгаа бөгөөд нийслэлийн иргэдийг 5 дугаар сарын 8-ны өдөр гэхэд нэгдүгээр тунд, 6 дугаар сарын 4-ний өдөр гэхэд хоёрдугаар тунд хамруулж дуусгахаар төлөвлөж байна.

Вакцин тариулсны дараа халуурах, тариулсан газарт хөндүүрлэх, толгой өвдөх, бие зарайх, үе мөч өвдөх, булчин өвдөх зэрэг хэсэг газрын болон ерөнхий биеийн урвал түгээмэл илэрч байна. АстраЗенека үйлдвэрийн лицензээр үйлдвэрлэсэн вакциныг тариулсан иргэдийн 55.5 хувьд, Синофарм үйлдвэрийн Вероцелл вакциныг тариулсан хүмүүсийн 13 хувьд, Пфайзер/БиоНТех үйлдвэрийн вакциныг тариулсан иргэдийн 41.8 хувьд түгээмэл илрэх хөнгөн урвал илэрсэн байна.

Вакцины төлөвлөлт, эмчийн үзлэг, вакцинд хамрагдсан иргэдийн бүртгэл, мэдээлэл, вакцины сертификатыг цахим бүртгэлийн системүүдэд бүртгэж, илэрч буй урвал, тандалт судалгаа, шинжилгээний ажлыг зохион байгуулж байна.

Зургаа. Гадаад улсаас иргэдээ татан авах талаар

2021 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн байдлаар хилийн "Буянт-Ухаа" боомтоор 160 удаагийн захиалгат нислэгээр 26,557 иргэн, газраар буюу Монгол-Орос, Монгол-Хятадын хилийн боомтоор 6,787 иргэн, нийт 33,344 иргэнээ мэргэжлийн байгууллагуудын хяналт дор зохион байгуулалттайгаар татан аваад байна.



НИЙТ 33,344 ИРГЭН

Зураг 2. Гадаад улс орноос иргэдээ татан авсан байдал

Улсын онцгой комиссын даргын 2021 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн 31 дүгээр тушаалаар "Тусгаарлан ажиглах үйл ажиллагааг зохицуулах түр журам" батлагдсантай холбогдуулан хилийн чанадаас ирэх иргэдийг зориулалтын байранд 7 хоног тусгаарлах горим хэрэгжиж эхэлсэн. Мөн коронавируст халдварын эсрэг вакцины бүрэн тун авснаас хойш 14 хоногийн хугацаа өнгөрсөн болон коронавируст халдвар авч, эдгэрсэн хүнийг тусгаарлахгүй байхаар шийдвэрлэсэн.

Долоо. Хандив, тусламжийн талаар

Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагаанд аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс нийт 8.9 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгө, 41.2 тэрбум төгрөгийн бараа материалын хандив, тусламж үзүүлсэн байна. Үүнээс:

- Улсын онцгой комисст 3.9 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгө, 5.1 тэрбум төгрөгийн бараа, материалын хандив, тусламж үзүүлснээс 450.7 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө, 117.1 сая төгрөгийн бараа, материалын үлдэгдэлтэй;
- ЭМЯ, МХЕГ, ХХЕГ, ЦЕГ, ХӨСҮТ, ЗӨСҮТ зэрэг төрийн байгууллагад 2.3 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгө, 34.7 тэрбум төгрөгийн бараа, материалын хандив цугласнаас 215.3 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө, 5.8 тэрбум төгрөгийн бараа, материалын үлдэгдэлтэй;
- Аймаг, нийслэлийн Онцгой комиссын үйл ажиллагааг дэмжиж 2.6 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгө, 1.4 тэрбум төгрөгийн бараа, материалын хандив, тусламж үзүүлснээс 313.5 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө, 757.4 сая төгрөгийн бараа, материалын үлдэгдэлтэй байна.

Хандив, тусламжаар төвлөрсөн мөнгөн хөрөнгө болон бараа, материалыг хүлээн авах, хуваарилах, хяналт тавих үйл ажиллагааг Засгийн газрын 2020 оны 133 дугаар тогтоолоор баталсан "Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах журам"-ын хүрээнд Улсын онцгой комиссын дарга болон Аймаг, нийслэлийн Онцгой комиссын даргын баталсан хуваарийн дагуу хэрэгжүүлж байна.

Улсын онцгой комисст ирүүлсэн хандив, тусламжийн мөнгөн хөрөнгийн орлого, зарцуулалт, худалдан авах ажиллагааны талаарх тайлан, мэдээллийг Онцгой байдлын ерөнхий газрын www.nema.gov.mn цахим хуудсаар тухай бүр мэдээлж байгаа болно.

-----oOo-----

Хандив, тусламжаар төвлөрсөн мөнгөн хөрөнгө болон бараа, материалыг хүлээн авах, хуваарилах, хяналт тавих үйл ажиллагааг Засгийн газрын 2020 оны 133 дугаар тогтоолоор баталсан "Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах журам"-ын хүрээнд Улсын онцгой комиссын дарга болон Аймаг, нийслэлийн Онцгой комиссын даргын баталсан хуваарийн дагуу хэрэгжүүлж байна.

Улсын онцгой комисст ирүүлсэн хандив, тусламжийн мөнгөн хөрөнгийн орлого, зарцуулалт, худалдан авах ажиллагааны талаарх тайлан, мэдээллийг Онцгой байдлын ерөнхий газрын www.nema.gov.mn цахим хуудсаар тухай бүр мэдээлж байгаа болно.

-----oOo-----